



**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
АЖЛЫН ХУГАЦАА ХЭТЭРЧ БАЙГАА НЬ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ
БУУРУУЛЖ БАЙНА.**



Аудитын тайлан

Аудитын нэр:

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

Аудитын нэр:

ҮАГ-ГАГ/2017/02-ГА-ХЭ,
ҮАГ-ГАГ/2017/04-ГА-ХЭ

АГУУЛГА

Аудитыг гүйцэтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	3
ҮАГ-ын харьяа Хэнтий аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-5
Тэргүүлэх Аудитор Ц.Энхтүвшин	Ерөнхий мэдээлэл	5-6
Аудитын менежер Б.Наранцэцэг	Бүлэг 1:	
Ахлах аудитор Н.Туяа	УТХО-ын төсөл, арга хэмжээг хуулийн хүрээнд төлөвлөсөн байна.	7
2017 оны 04 дүгээр сарын 20	- УТХО-аар хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээнүүд аймгийн 2016 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан байна. - УТХО-ын ихэнх нь өмнөх оноос шилжин хэрэгжиж буй томоохон төсөл арга хэмжээнүүд байна.	7-8 8-9
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудал байвал 70562147, 98332147 дугаарын утас, 70562112 дугаарын факсаар харилцана уу	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 25.5 хувийг Улсын төсвийн байгууллагууд болон хувийн өмч хөрөнгөд хамаарах объектод ТАХ хэрэгжүүлэхээр тусган баталжээ.	9
ХАЯГ:	- ОНТХО-ын ТАХ-г төлөвлөхдөө сум, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, зайлшгүй хэрэгцээ шаардлагыг үндэслэн төлөвлөжээ. - ОНТХО-ын зарим ТАХ-г зураг төсөвгүйгээр төлөвлөж, баталдаг зөрчил дахин давтагдаж байна. - ОНТХО-ын ТАХ-г “Төсвийн тухай” хуулийн холбогдох заалтад нийцүүлэн төлөвлөж батлах шаардлагатай байна.	9-10 10 10-11
Хэнтий аймаг Хэрлэн сум Аймгийн ЗДТГ-ын байр 325 тоот	Дүгнэлт.....	11
	Зөвлөмж.....	11
	Бүлэг 2:	
	Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж ажилласан байна.	12
	- УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулжээ. - ОНХО-ын ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хуулийн хүрээнд зохион байгуулжээ. - Сумын ТЕЗ нар эрх шилжиж ирсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааг ил тод мэдээлээгүй байна.	12 12 13
	Дүгнэлт.....	14
	Зөвлөмж.....	14
	Бүлэг 3:	
	УТХО-аар хэрэгжиж буй зарим барилгын ажил удааширалтай байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.	15
	- УТХО-ын хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээний заалтуудыг нарийвчлан тусгаагүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй байна. - Орон нутагт санхүүжилтийг зориулалтын дагуу бүрэн олгосон байна.	15 16

	■ УТХО-ын санхүүжилтийг гэрээнд заасны дагуу хугацаанд нь бүрэн олгохгүй байгаа нь ТАХ-ний хугацаа хэтрэлтэд нөлөөлж байна.	16
	■ Хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгжилтэд тавих хяналт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.	19
	■ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэн ашиглалтанд хүлээлгэн өгсөн зарим ТАХ-ний үр дүн хангалтгүй, чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байна.	19-20
	■ УТХО-аар баригдсан барилга байгууламж, нийлүүлсэн тоног төхөөрөмжийг данс бүртгэлд бүртгэсэн эсэхэд салбарын яамнаас тавих хяналт хангалтгүй байна.	21
	Орон нутгийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний гэрээ 100 хувь бүрэн хэрэгжсэн байна.	22
	■ Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцлүүд тодорхойгүй, ерөнхий байдалтай байна.	22
	■ Орон нутагт санхүүжилтийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.	23
	■ Гэрээний хугацаа хэтрэлтэд алданги тооцох боломжгүй болжээ.	23
	■ Сумын ТЕЗ-д эрх шилжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт дутмаг байна.	23
	■ ТАХ-г улсын комисс хүлээж аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.	24
	■ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тодорхой ажлуудын үр дүн, үр ашиг сайн байна.	24-25
	Дүгнэлт.....	26
	Зөвлөмж.....	27
	Бүлэг 4:	
	Векселийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилт, үр дүн, үр ашиг	28
	■ 2016 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон хуулиар векселиэр санхүүжүүлэх ТАХ –г УТХО-тай давхардуулан баталсан байна.	29
	■ ТАХ-ний зориулалтыг өөрчилж хэрэгжүүлсэн байна.	29-30
	■ Санхүүжилтийг цаг хугацаанд нь олгоогүйгээс ТАХ-ний хэрэгжилтийн хугацаанд нөлөөлж байна.	30
	■ Улсын комиссын актаар хүлээн авч, ашиглалтад оруулсан зарим сургуулийн барилгын сантехник, дулааны шугам сүлжээнд доголдол гарч байна.	30
	Дүгнэлт.....	31
	Зөвлөмж.....	31
	Холбогдох байгууллагын санал:	33

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ЗД	Засаг дарга
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗЗНДНТУТХ	Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
ХХААЯ	Хүнс хөдөө аж ахуйн яам
ЭМСШУЯ	Эрүүл мэнд, соёл, шинжлэх ухааны яам
БСШУЯ	Боловсрол, соёл шинжлэх ухааны яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам
ЗТБХБ	Зам тээвэр, барилга хот байгуулалт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗАА	Захирагчийн ажлын алба
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ОНӨА	Орон нутгийн өмчийн алба
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
БЗӨБЦТС	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх салбар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗНХҮЧ	Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
ЭЗН	Эдийн засаг нийгэм
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ААН	Аж ахуйн нэгж
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ХАА	Худалдан авах ажиллагаа

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий Аудитор ТҮндэсний аудитын газрын 2017 онд нийлүүлэх ажил, үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаалыг үндэслэн “Төрийн аудитын тухай” хуулийн 15.1.5-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Аудитын газар гүйцэтгэлийн аудит хийлээ.

2. Аудитын зорилт:

Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэнд аудит хийж дүнг ЯАГ, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх,
- Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн Банкнаас 2016 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн
- Векселиэр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитаар 2016 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагч, орон нутгийн эрх бүхий байгууллагуудыг хамруулан шалгалаа.

4. Аудитын арга зүй, стандарт мөрдөлт:

Аудитын явцад аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ОНӨА, СТСХ-ийн холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга авч, тэмдэглэл хөтлөн, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг данс бүртгэлтэй тулгаж, газар дээр нь очиж биетээр үзэн, баталгаажуулж, харьцуулалт хийсэн ба аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, бусад шаардлагатай баримт материал, судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 300, 3000-3100)-ийг ашиглан гүйцэтгэсэн.

5. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамжинд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримтад хавсаргав.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- 1) Төрийн аудитын тухай хууль,
- 2) Төсвийн тухай хууль,
- 3) Монгол улсын 2016 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт хийсэн тухай хууль
- 4) ЗЗНДНТУ-ын тухай хууль,
- 5) ТБОНӨХБАҮХА-ний тухай хууль,
- 6) НББ-ийн тухай хууль,
- 7) Барилгын тухай хууль,
- 8) Дээрхи хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд,
- 9) Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”,
- 10) Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам,
- 11) Гүйцэтгэлийн аудитын стандарт, гарын авлага
- 12) Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

6. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Энхтүвшин удирдан зохион байгуулж, аудитын менежер Б.Наранцэцэг аудитын үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Туяа төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэлээ.

7. Хүндрэл бэрхшээл

Аудитыг гүйцэтгэхэд цаг хугацаа болон хүн хүчний нөөцийн хязгаарлагдмал байдал нөлөөлсөн болно.

8. Аудитын хугацаа.

Аудитыг 2017 оны 03-р сарын 02-нд эхэлж, 2017 оны 04-р сарын 20-нд дуусгав.

9. Аудитын дүн.

Ерөнхий мэдээлэл

Хэнтий аймагт 2016 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийтдээ 19436.4 сая төгрөгийн 42 ТАХ-ний хөрөнгө оруулалт батлагдсанаас 7881.1 сая төгрөгийн 6 ТАХ-ний эрх орон нутагт шилжин хэрэгжсэн ба 20 ТАХ-ний 955.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

2016 онд санхүүжих төсөл, арга хэмжээ:

	Төрөл	2016 онд хөрөнгө оруулалтад батлагдсан зардал		үүнээс: 2016 онд эрх шилжиж ирсэн	
		TAX	дүн /сая.төг/	TAX	дүн /сая.төг/
УТХО		13	15,757.3	5	7,530.5
1	Барилга байгууламж	9	14640.8	2	7394.0
2	Их засвар	4	335.1	3	136.5
3	Тоног төхөөрөмж		781.40		
Вексель		8	2373	0	0
1	Барилга байгууламж	8	2373.0		
ОНХО		21	1306.1		
1	Барилга байгууламж	5	886.7		
2	Их засвар	3	99.0		
3	Машин, Тоног төхөөрөмж, тавилга	13	320.4		
Нийт ХО		42	19,436.4	5	7,530.5
1	Барилга байгууламж	22	17900.5	2	7394
2	Их засвар	7	434.1	3	136.5
3	Тоног төхөөрөмж	13	1101.8	0	0

Нийт TAX-ний 92.1 хувийг барилга байгууламжид, 2.2 хувийг их засвар, 5.7 хувийг тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулахаар баталжээ.

Эрх шилжиж ирсэн болон орон нутгийн хөрөнгө оруулалтын 25 TAX-нээс 23 TAX-ний худалдан авах ажиллагааны дүнд 2016 онд 2.3 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.

Хэнтий аймагт хэрэгжсэн TAX-ний хэрэгжилтэд аймгийн төрийн сангаар дамжуулан олгосон 8472.5 сая төгрөгийн санхүүжилтийн 947.3 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад, 7525.2 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 20 TAX-г 955.5 сая төгрөгөөр төсөвлөж, тендер шалгаруулалтын дүнд 953.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр гэрээнд тусгажээ. Мөн Засгийн газрын 2016 оны 10 сарын 05 ны хуралдаанаар ЗГ-ын нөөц сангаас Шинэ Өндөрхаан хорооллын гадна цахилгаан хангамжийн угсралтын ажилд 350.6 сая төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсэн байна.

2016 онд УТХО-аар Хэрлэн суманд 928 хүүхдийн, Батширээт суманд 320 хүүхдийн 2 сургуулийн барилга, Баянмөнх суманд Хэрлэн голын төмөр бетонон гүүр, Векселийн хөрөнгөөр ГХБХБГ-ын конторын барилга тус тус шинээр ашиглалтанд орсон байна.

Аудитаар нийт 2182.3 сая төгрөгийн зөрчил дутагдал илрүүлж, 1304.4 сая төгрөгийн зөрчилд 12 зөвлөмж, 108.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх 6 албан шаардлага хүргүүлж, 5 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал хүргүүлж ажиллалаа.

БҮЛЭГ 1: УТХО-ын төсөл арга хэмжээг хуулийн хүрээнд төлөвлөжээ.

А.Улсын төсвийн хөрөнгө оруулалт

УТХО-аар хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээнүүд аймгийн 2016 оны ЭЗНХҮЧ-д тусгагдсан байна.

А.1. Хэнтий аймагт 2016 оны “Төсвийн тухай” хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын 20 ТАХ-ээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10 ТАХ-г 10615.4 сая төгрөгөөр, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх 3 ТАХ-г 4360.5 сая төгрөгөөр, векселиэр санхүүжүүлэх 8 ТАХ-г 2373.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталжээ.

УТХО болон Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр баталсан ТАХ-г хүснэгтээр үзүүлвэл:

Хуулийн дугаар	ТЕЗ	Эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Х.2.1.17	БСШУСС	УТХО	Соёлын төвийн барилга, 300 суудал /Хэнтий, Баян-Адлага сум/	2014	2016	1000	50.0
Х.1.1.1.24	БСШУСС	УТХО	Сургуулийн барилга, 928 суудал /Хэнтий, Хэрлэн сум, 1 дүгээр сургууль/	2012	2016	5,089.90	1,374.50
Х.1.1.1.26	БСШУСС	УТХО	Сургуулийн барилга, 320 суудал /Хэнтий, Батширээт сум/	2013	2016	1,687.50	861.3
Х.1.1.1.27	БСШУСС	УТХО	Сургуулийн барилгын өргөтгөл, спорт заалын барилга /Хэнтий, Хэрлэн сум, "Ханхэнтий" цогцолбор/	2013	2016	2,401.80	600.5
ХҮ.1.2.4	ЭМС	УТХО	Уламжлалт анагаах ухааны төвийн их засвар /Хэнтий, Өндөрхаан/	2015	2016	406	198.6
Х.2.1.7	БСШУСС	УТХО	Ханхэнтий чуулгын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2011	2017	8,353.70	1,079.20
ХҮ.1.1.3	ЭМС	УТХО	Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2012	2016	12,450.90	6,314.80
Х.1.2.2	БСШУСС	УТХО	Сургуулийн халаалтын тогооны засвар /Хэнтий, Баянхутаг сум/	2016	2016	27.0	27.0
	БСШУСС	УТХО	Сургуулийн уурын зуухны барилга /Хэнтий, Өлзийт сум/	2016	2016	79.5	79.5
	БСШУСС	УТХО	Цэцэрлэгийн барилгын засвар /Хэнтий, Хэрлэн сум, 4 дүгээр цэцэрлэг/	2016	2016	30.0	30.0
			УТХО-ын дүн			31,526.30	10,615.40
74		Хөгжлийн банкны эх үүсвэрээс	Хэрлэн голын төмөр бетон гүүр /Хэнтий, Баянмөнх сум/	2011	2016	3,800.00	736.3
76		Хөгжлийн банкны эх үүсвэрээс	Багануур-Цэнхэрмандалын 35 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Хэнтий /	2015	2016	3,415.80	2549.7
93		Хөгжлийн банкны эх үүсвэрээс	Инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/	2014	2017	4,374.30	1,074.50
			Хөгжлийн банкны эх үүсвэрийн дүн			11,590.1	4,360.5

Эдгээр ТАХ-ний 7530.5 сая төгрөгийн УТХО-ын 5 ТАХ нь салбарын сайдаас аймгийн Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн бол 15 ТАХ нь эрх шилжээгүй хэрэгжсэн байна.

А.2. “Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого /2010-2021/” –ыг Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2010 оны 05 сарын 22-ны өдрийн 04 тоот

тогтоолоор батлагдсан боловч хөрөнгө оруулалтын талаар нарийвчлан тусгаагүй байна.

Хэрэгжсэн ТАХ-нээс 8 ТАХ нь Хэнтий аймгийн ЭЗН-ийг хөгжүүлэх 2016 оны үндсэн чиглэлд тусгагдсанаас хэрэгжилт 62.5 хувьтай биелж, үлдэх хувь нь хэрэгжиж байгаа боловч дуусаагүй байна.



Эрх шилжсэн 5 ТАХ-ний 3 нь боловсролын салбарын, 1 нь соёл, спорт, аялал жуулчлалын салбарт, 1 нь эрүүл мэндийн салбарт тус тус төлөвлөгджээ.

А.3. УТХО-ын санхүүжилтийн эх үүсвэрийн хуваарилалтыг УИХ Төсвийн тухай хуулиар баталдаг учир орон нутагт хамааралгүй байна.

А.4. 2016 онд салбарын сайдын багцаас эрх шилжиж ирсэн 5 ТАХ-нээс Баянхутаг сумын сургуулийн халаалтын тогооны засвар, Өлзийт тосгоны сургуулийн зуухны барилгын засвар, Хэрлэн сумын 4-р цэцэрлэгийн засварын ажлууд шинээр хэрэгжсэн бол Хан Хэнтий чуулгын барилга, аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажлууд он дамжин хэрэгжсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ихэнх нь өмнөх оноос шилжин хэрэгжиж буй томоохон төсөл, арга хэмжээнүүд байна.

А.5. Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсээс Төсвийн тухай хуулийн 28.3.2, 28.3.3-т заасан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үр дүнтэй болохыг урьдчилсан судалгаагаар тогтоож, 7 сумын ЗДТГ-ын барилга барих, 1 тосгоны ЗАА-ны байрны их засвар хийх ТАХ-ний жагсаалтыг 2016 оны Төсвийн тухай хуульд тусгуулахаар аймгийн Засаг даргын 2015/07/29-ны өдрийн 9/1106 дугаартай албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлжээ.

Мөн 2016 оны Төсвийн тухай хуульд тусгуулахаар Эрүүл мэнд, спортын яаманд 1 ТАХ, БСШУЯ-нд 11 барилга, 5 засвар, 1 тоног төхөөрөмж, өмнөх оноос дамжин хэрэгжих 5 барилгын ажлыг, ХХААЯ-нд 1 барилгын, Зам тээврийн яаманд 3 гүүр барих ажлыг тусгуулахаар аймгийн Засаг даргын 2015/07/29-ны өдрийн 9/1106 дугаартай албан бичгээр, БХБЯ-нд шинээр 3 ТАХ, он дамжиж хэрэгжиж байгаа 2 ТАХ-ний, Эрчим хүчний яаманд 5 ТАХ-г тусгуулахаар 9/1105 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлжээ.

Гэвч Монгол Улсын 2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалтад аймгийн ЗД-аас хүргүүлсэн саналаас шинээр томоохон барилга байгууламжийн ажил батлагдаагүй ба БСШУС-ын багцад шинээр Баянхутаг сумын сургуулийн уурын зуухны засвар, Өлзийт тосгоны сургуулийн халаалтын засвар, Хэрлэн сумын 4-р цэцэрлэгийн цахилгааны засварын ТАХ-г нэмж тусгажээ.

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулиар өмнөх онуудад хэрэгжиж эхэлсэн, дуусаагүй он дамжсан томоохон барилга байгууламжийн ажлууд ихэвчлэн тусгагдаж батлагдсан байна.

Төсвийн тухай хуульд ТАХ-г давхардуулан баталсан байна.


А.6. Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан хуулиар УТХО-аар санхүүжүүлэх ТАХ-г төлөвлөж батлахдаа Хан Хэнтий чуулгын барилгыг 1079.2 сая төгрөгөөр улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр баталсан бол 1042.8 сая төгрөгийг векселээр санхүүжүүлэхээр давхар баталсан байна.

Б. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

Орон нутгийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөхдөө сум, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, зайлшгүй хэрэгцээ шаардлагыг үндэслэн төлөвлөжээ.

Б.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх ТАХ-ний төлөвлөлтийг боловсруулахдаа сум болон байгууллагын санал, хүсэлтийг аймгийн ЗДТГ-ын СТСХ, ХБХ хүлээн авч судлан, аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн эрэмбэлж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар баталдаг байна.

Аймгийн ИТХ-ын 2015 оны арвангуравдугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор аймгийн 2016 оны төсвийг батлаж ОНХО-ыг 80.0 сая төгрөгөөр, замын сангаас 238.5 сая төгрөгөөр баталсан бол 2016 оны 05 сарын 02-ны арвандолоодугаар хуралдааны 16 тоот тогтоол, 12 сарын 02-ны гуравдугаар хуралдааны 01 дүгээр тогтоолоор ОНХО-ыг 512.5 сая төгрөгөөр, замын сангаас 443.0 сая төгрөгөөр тодотгон баталсанаас автомашин худалдан авах 2, тоног төхөөрөмж худалдан авах 11, барилга байгууламж 4, их засвар 3, нийт 20 төсөл арга хэмжээг 955.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусгасан байна.



Тус батлагдсан төсөл арга хэмжээг ангилбал: Нийт хөрөнгө оруулалтын 20%-ийг барилга байгууламж, 10%-ийг автомашин, 55%-ийг тавилга, тоног төхөөрөмж, 15%-ийг их засварын төсөл, арга хэмжээ эзэлж байна.

Нийт төлөвлөсөн хөрөнгө оруулалтад Бор-Өндөр МСҮТ-ийн авто засварын төв худалдан авахад 55.3 сая төгрөг, Дадал сумын Хилийн цэргийн 0287 дугаар

ангийн штаб, буудлын барилгын өргөтгөл барихад 52.8 сая төгрөг, Хэрлэн сумын С-79-р байрны мансардны засаврт 80.0 сая төгрөг, Цагдаагийн иргэдэд үйлчлэх танхимын засварт 4.0 сая төгрөг, 2 сумын ЗДТГ-т автомашин авахад 80.0 сая төгрөг, төрийн ёслол хүндэтгэлийн өргөөний тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, ханын зурагт 102.2 сая төгрөг, төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж дагалдах хэрэгсэл, дугаарлалтын машин, үнэлгээний систем, камер, программ хангамж 71.8 сая төгрөг, 4 байгууллагад тавилга, тоног төхөөрөмж 61.5 сая төгрөгөөр худалдан авахаар тусгасан байна.

Б.2. Орон нутгийн замын сангаас Хэрлэн сумын 2-р багт авто зам барихад 388.0 сая төгрөг, Гурванбаян тосгоны Дундбаяны модон гүүр барихад 40.0 сая төгрөг, Өмнөдэлгэр сумын Жаргалантын гүүрний засварт 15.0 сая төгрөгийг тус тус баталжээ.

ОНХО-ын зарим ТАХ-г зураг төсөвгүйгээр төлөвлөж баталдаг зөрчил дахин давтагдаж байна.

Б.3. Хуульд заагдсан чиглэлийн дагуу хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тусгуулах санал ирүүлсэн 12 ТАХ, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн 2016 оны үндсэн чиглэлд тусгагдсан 8 ТАХ, санхүүгийн тооцоолол, зураг төсөв, санхүүгийн тооцоололтой 15 ТАХ байна.

Гурванбаян тосгоны Дундбаяны модон гүүр барих ажил, Өмнөдэлгэр сумын Жаргалантын гүүрний засварыг батлагдсан зураг төсөвгүйгээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29.4¹ дэх заалт, Барилгын тухай хуулийн 24.1² дахь заалтыг зөрчсөн байна.

Мөн аймгийн ИТХ-аас зайлшгүй шаардлагатай гэж үзсэн С-79 байрны мансардны засвар, 2 сумын ЗДТГ-ын автомашин худалдан авах ТАХ-г хуралдаанаар хэлэлцэн баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын дүнг өмнөх онтой харьцуулахад 2015 онд 29 ТАХ-г 1053.2 сая төгрөгөөр баталсан бол 2016 онд 20 ТАХ-г 955.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталж, өмнөх оноос ТАХ –ний тоо 9, дүн 97.7 сая төгрөгөөр буурчээ.

Хөрөнгө оруулалтын ТАХ-г Төсвийн тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэн төлөвлөж, батлах шаардлагатай байна.

Б.4. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тусгагдаж батлагдсан 20 ТАХ-г авч үзэхэд хэрэгцээ шаардлагыг үндэслэн төлөвлөсөн боловч Төсвийн тухай хуулийн 4.1.24 “**хөрөнгө оруулалт**” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”, 6.6.6 “**тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх**” гэсэн заалтуудын шаардлагыг хангаагүй Бор-Өндөр сумын МСҮТ-ийн авто засварын төв 55.3 сая төгрөг, Дадал сумын Хилийн цэргийн 0287-р ангийн штаб, буудлын барилгын өргөтгөл 52.8 сая төгрөг, Татварын хэлтэс компьютер, принтер 32.3 сая төгрөг, ХХААГазрын хог хаягдал шатаах зуух барих 5.0 сая төгрөг, Аймгийн МСҮТөвд сандал 13.5 сая төгрөг, Цагдаагийн газрын иргэдэд үйлчлэх танхимийн засварын ажил 5.0 сая төгрөгийн, нийт 163.9 сая төгрөгийн 6 ТАХ нь улсын төсвийн байгууллагуудад хэрэгжүүлэхээр батлагджээ.

Мөн хувийн компанийн дутуу барьж гүйцэтгэсэн хувийн өмчид хамаарах С-79 байрны мансардны засварын ажилд 80.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагджээ.

¹ "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэс¹лэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана."

² Барилга байгууламжийн төсвийн тооцоо хийх, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтлана: 24.1.1. батлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх;

Нийт 243.9 сая төгрөгийн 7 ТАХ нь хуулийн шаардлагад нийцээгүй, орон нутгийн өмчлөлд хамаарахгүй ТАХ-нүүд тусгагджээ. Энэ нь ОНХО-ын батлагдсан төсөвт зардлын 25.5 хувийг эзэлж байна.

Гэвч нөгөө талаас улсын төсвийн байгууллагуудад батлагдсан хөрөнгө оруулалт нь Төсвийн тухай хуулийн 58.2 “**Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ: 58.2.17. хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх**”, мөн салбарын хуулиуд, тухайлбал Цагдаагийн албаны тухай хуулийн 94.1.”**Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчийг орон байр, хүнс, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, томилогдсон алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж болно.**” гэсэн заалтуудтай зөрчилдөж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г хуульд нийцүүлэн төлөвлөсөн боловч Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г Төсвийн тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэн төлөвлөж батлах шаардлагатай байна.
2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөхдөө сум, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, зайлшгүй хэрэгцээ шаардлагыг үндэслэн төлөвлөжээ.
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зарим ТАХ-г зураг төсөвгүйгээр төлөвлөж, баталдаг зөрчил дахин давтагдаж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргад:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа Төсвийн тухай хуулийн 4.1.24, 29.4 дэх заалтад нийцүүлэн хуулийн шаардлага хангасан, зураг төсөвтэй ТАХ-г төлөвлөх

БҮЛЭГ 2: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж ажилласан байна.

А. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулжээ.

А.1 Аймгийн 2016 онд УТХО-ын санхүүжилтээр хэрэгжүүлэх БСШУЯ-аас эрх шилжүүлсэн 3 их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, орон нутгийн ААН-ээр гүйцэтгүүлсэн байна. Үүнд:

- *Баянхутаг сумын сургуулийн халаалтын тогооны засварын ажлыг харьцуулалтын аргаар хуулийн хугацаанд зохион байгуулсан байна.*

Аймгийн Засаг даргын 2016 оны 04 сарын 04-ны А/148 дугаар захирамжаар Өлзийт тосгоны сургуулийн засварын ажил, Хэрлэн сумын 4-р цэцэрлэгийн засварын ажлыг Хэрлэн сумын Засаг даргад эрх шилжүүлсэн байна.

- *Хэрлэн сумын Засаг дарга захирамжаар үнэлгээний хороог хуулийн дагуу байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан Өлзийт тосгоны сургуулийн засварын ажлыг 30.1.1 дэх нөхцөл үүссэн тул 30.4.3 дэх заалтын дагуу шууд гэрээ байгуулах, Хэрлэн сумын 4-р цэцэрлэгийн цахилгааны засварын ажлыг 33.4 дэх заалтын дагуу шууд гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн байна.*

А.2 БСШУЯ-аас аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн сургууль, цэцэрлэгийн 3 их засварын ажлын худалдан авах ажиллагааг ил тод зарлаж, хуулийн дагуу зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

УТХО-аар хэрэгжих ТАХ-ний худалдан авах ажиллагаанаас хэмнэлт гараагүй байна.

А.3 Эрх шилжүүлсэн УТХО-аар хэрэгжүүлсэн барилгын засварын ажлын 132.5 сая төгрөгийн төсөвт өртөг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсанаас худалдан авах ажиллагааны үр дүнд хэмнэлт гаргаагүй байна.

Б. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

ОНХО-ын ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хуулийн хүрээнд зохион байгуулжээ.

Б.1 Аймгийн ИТХ-ын 2015 оны арвангуравдугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор аймгийн 2016 оны төсвийг батлаж ОНХО-ыг 80.0 сая төгрөгөөр, замын сангаас 238.5 сая төгрөг, 2016 оны арвандолоодугаар, гуравдугаар хуралдаанаар ОНХО-ыг 512.5 сая төгрөгөөр, замын сангаас 443.0 сая төгрөгөөр аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ний жагсаалтыг тодотгон баталсан байна.

Б.2. Аймгийн ИТХ-ийн тогтоолоор батлагдсан орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тендерийн урилгыг худалдан авах ажиллагааны [www.e-procurement](http://www.e-procurement.mn), www.meps.gov.mn сайтад байршуулан ил тод зарлаж, зарим ХАА-г цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

Б.3. Аймгийн Засаг дарга орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 708.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 ТАХ-ний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу 4 ТАХ-г харьцуулалтын аргаар, 4 ТАХ-г шууд гэрээ байгуулах журмаар, 5 ТАХ-г шууд худалдан авалт хийсэн ба Хэрлэн сум 800 м замыг концессийн төрлөөр зохион байгуулан шалгаруулж, захиалагчид зөвлөмжийг хүргүүлсэн байна.

ОНТХО-аас 247.0 сая төгрөгийн 7 ТАХ-ний эрхийг сумын Засаг даргад шилжүүлснээс 5 ТАХ-г харьцуулалтын аргаар, 2 ТАХ-г шууд гэрээ байгуулах журмаар зохион байгуулжээ.

Б.4. Монгол улсын Засгийн газрын 2016 оны 10 сарын 05-ны хуралдаанаар Засгийн газрын нөөц хөрөнгөөс “Шинэ Өндөрхаан орон сууцны хорооллын гадна цахилгаан хангамжийн угсралтын ажил”-д 350.6 сая төгрөгийг олгохоор шийдвэр гарган хуулийн 34.1.5 дахь заалтын дагуу аймгийн ЗДТГ нь БЗӨБЦТС ТӨХК-ийн Хэнтий ЦТССалбартай шууд гэрээ байгуулан ажилласан байна. Үүнд сонгон шалгаруулалт зохион байгуулахад хорооллын өвөлжилт, дулааны асуудлыг шийдвэрлэх цаг хугацааны хязгаарлагдмал байдал нөлөөлжээ.

Б.5 Сумын ТЕЗ-д эрх шилжүүлсэн Өмнөдэлгэр сум, Гурванбаян сумын нутагт гүүр барих 2 ТАХ-ний гүйцэтгэгчийг шалгаруулахад тусгай зөвшөөрөлгүй ААН, иргэдийн бүлгээр гүйцэтгүүлсэн нь “Авто замын тухай” хуулийн 13.2³, 13.3⁴ заалтыг зөрчсөн ба өмнөх аудитаар Гурванбаян сумын ЗАА-ны даргад хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Үүнд тендерт өөр оролцогч санал ирүүлээгүй тул дээрх ААН, иргэдийн бүлгийг сонгосон байна.

ОНХО-ын худалдан авалтын үр дүнд 2.3 сая төгрөгийн хэмнэлт гарчээ.

Б.6 Бор-Өндөр сумын МСҮТ-ийн авто засварын төв худалдан авахад 55.3 сая төгрөг төлөвлөснөөс худалдан авалтын дүнд 2.3 сая төгрөгийн хэмнэлт гаргажээ.

Сумын ТЕЗ нар эрх шилжиж ирсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааг ил тод мэдээлээгүй байна.

Б.7 Шилэн дансны нэгдсэн цахим сайтад хөрөнгө оруулалтын ТАХ-ний худалдан авах ажиллагааны тайланг мэдээлсэн эсэхийг шалгахад эрх шилжиж ирсэн УТХО болон ОНТХО-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг ТЕЗ-ийн шилэн дансны мэдээллийн “хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт” гэсэн хэсэгт аймгийн ТЕЗ, Хурх тосгоны ТЕЗ мэдээллийг байршуулсан байна.

Б.8 Харин Хэрлэн, Баян-Адрага, Баян-Овоо, Дадал, Өмнөдэлгэр сумын ТЕЗ нар эрх шилжин хэрэгжсэн ТАХ-ний мэдээллийг байршуулаагүй, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг бүрэн хангаагүй, Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

³ Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлан хамгаалах ажлыг тусгай зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээд зохих журмын дагуу гэрээ байгуулж гүйцэтгэнэ

⁴ Авто зам, замын байгууламжийг шинээр барихад авто зам, замын байгууламжийг барих тусгай зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээд тендер /төсөл сонгон шалгаруулалт/-т оролцож шалгарсан тохиолдолд захиалагч байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгэнэ

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. ТАХ-ний худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулсан байна.
2. ОНХО-ын худалдан авалтын дүнд 2.3 сая төгрөгийн хэмнэлт гарчээ.
3. Сумдад гүүр барих ажилд тусгай зөвшөөрөлгүй ААН-ийг шалгаруулж, гүйцэтгүүлсэн нь холбогдох хуулийн заалтыг зөрчсөн байна.
4. Сумын ТЕЗ нар худалдан авах ажиллагааны үр дүн, тайланг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй, ил тод байдлыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Орон нутгийн өмчийн албаны даргад:

Сумын ТЕЗ нарын дараах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах. Үүнд:

1. Орон нутгийн зам, замын байгууламжийн худалдан авах ажиллагаанд тусгай зөвшөөрөл бүхий ААН-ийг шалгаруулах
2. Сумын ТЕЗ-ын худалдан авах ажиллагааны тайланг журмын дагуу цахим хуудсанд тухай бүр мэдээлэх

БҮЛЭГ 3: УТХО-аар хэрэгжиж буй зарим барилгын ажил удаашралтай байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

А. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээний заалтуудыг нарийвчлан тусгаагүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй байна.

А.1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажлыг 2013 оны 5 сард эхлүүлсэн боловч одоог хүртэл дуусаагүй байна. ЭМС-ын 2015 оны 5 сарын 14-ний 198 дугаар тушаалаар аймгийн Засаг даргад ажил гүйцэтгүүлэх эрх шилжүүлсэн байна.

Сайдын эрх шилжүүлсэн тушаалын дагуу 2015 оны 6 сарын 12 нд барилгын ажлын зураг төсөв, баримт бичгийг акт үйлдэн хүлээлцэж, аймгийн Засаг дарга Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажлыг гүйцэтгүүлэх гэрээг “Хар чонот” ХХК-тай байгуулсан байна. Гэрээнд “Гүйцэтгэгч нь өмнөх гүйцэтгэсэн аймгийн МСҮТ-ийн барилгын дутуу хийгдсэн ажлууд болон Тэмүүжин цогцолбор сургуулийн гадна бохир усны шугамын засвар эдгээр барилгуудтай холбоотой орхигдсон, гологдол ажлуудыг 2015.7.15-2015.08.25 ний хооронд хийх үүрэг хүлээх ба үүргээ биелүүлээгүй тохиолдолд дээрхи ажлуудын төсөвт өртөгтэй тэнцэх хэмжээний мөнгийг гэрээний дүнгээс үл маргах журмаар суутган тооцно” гэж заажээ.

Гэвч гэрээ байгуулсан он сар өдөргүй, санхүүжилтийн талаар нарийвчлан тусгаагүй, хугацаа хэтрэлтэд алданги тооцох заалтгүй байгуулж, ХБХэлтэс нь гэрээний биелэлтийг дүгнээгүй, гэрээний хугацаа хэтэрсэн байна.

Мөн 2017 оны 01 сарын 23-ны өдрийн А/35 дугаар тушаалаар аймгийн Засаг даргад ажил гүйцэтгүүлэх эрх шилжүүлсний дагуу 2017 оны 01 сарын 27-нд аймгийн Засаг даргатай ажил гүйцэтгэх гэрээг сунган байгуулжээ. Гэрээнд барилгын төсөвт өртгийг 4045.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 16473.7 сая төгрөгөөр, ажлыг 2017 оны 2 сарын 25-нд дуусган улсын комисст хүлээлгэн өгөхөөр тусгажээ.

Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга дээр нийт 4045.6 сая төгрөгийн нэмэлт ажил, үнийн зөрүү гарсан ба Барилгын хөгжлийн төвийн экспертизээр орж Магадлалын ерөнхий дүгнэлт хийлгэж 2017 оны улсын төсөвт батлагдсан байна. Дараах нэмэлт ажлууд орж хийгдэж дууссан. Үүнд:

- Тус барилгын тендерийн анхны төсөв нь ЗТБХБ-ын сайдын 2012 оны 01-р сарын 13-ны өдрийн 18 дугаар тушаалыг баримтлан хийгдсэн бөгөөд одоо мөрдөж буй ЗТБХБ-ын сайдын 2012 оны 08-р сарын 13-ны өдрийн 181 дүгээр тушаалаар барилгын төсөв зохиох дүрмийг шинэчлэн баталсаны дагуу цалин, материалын үнийн зөрүү гарсан,
- Мөн тендерийн төсөвт тусгаагдаагүй байсан ажлууд болон захиалагч, ашиглагч байгууллагын хүсэлтийн дагуу нэмэлт ажлууд хийгдэж, төсөв гарган батлуулсан байна.

А.2. БСШУ-ны сайд Хан Хэнтий чуулгын барилгын ажлыг хэрэгжүүлэхээр “Хөвсгөл геологи” ХХК-тай 2012 оны 5 сарын 23-ны өдөр 3500.0 сая төгрөгийн өртөгөөр 2013 оны 08 сарын 23-нд ашиглалтанд оруулахаар гэрээ байгуулан ажилласан боловч

салбарын яамнаас гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй эрх шилжүүлж, дараагийн “Макс майнд” ХХК-тай аймгийн Засаг дарга гэрээ байгуулжээ.

Хан Хэнтий чуулгын барилга угсралтын ажлын явц болон хугацаа хэтрэлтэд өмнөх тендерийн ажлыг гүйцэтгэсэн “Хөвсгөл геологи” ХХК-ийн ажлын чанар хангалтгүй байгаа нь нөлөөлсөн байна.

УТХО-ын санхүүжилтийг гэрээнд заасны дагуу хугацаанд нь бүрэн олгохгүй байгаа нь ТАХ-ний хугацаа хэтрэлтэд нөлөөлж байна.

А.3. БСШУ-ны сайдын 2015 оны 06 сарын 30-ны А/261 тоот тушаалаар эрх шилжүүлсний дагуу аймгийн Засаг даргын “Макс майнд” ХХК-тай 2015 оны 8 сарын 25-нд байгуулсан гэрээнд барилгыг 4689.6 сая төгрөгөөр барьж 2016 оны 05 сарын 01 нд ашиглалтанд оруулж, гэрээг 2016 оны 07 сарын 01-ний дотор дүгнэхээр заасан байна.

Гэвч захиалагч тал “Макс Майнд” ХХК-д 2015, 2016 онд гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олгоогүйгээс барилгын ажил хугацаандаа хэрэгжихгүйд нөлөөлж, 2016 оны 3 сарын 22-ны байдлаар ажлын гүйцэтгэл 67 хувьтай, гэрээний хугацаа хэтэрсэн байна. Иймээс 2017 оны 2 сарын 16- ний өдрөөс 10 сарын 01-ний өдөр хүртэл гэрээг сунгасан байна.

Орон нутагт санхүүжилтийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

А.4. Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь “Төрийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын дагуу ГХБХБГ-ын баталгаажуулсан гүйцэтгэлийн хувиар санхүүжилтийг олгожээ.

Хэнтий аймагт батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-нээс эрх шилжиж ирсэн ТАХ-д аймгийн төрийн сангаар дамжуулан 7525.2 сая.төгрөгийг санхүүжүүлсэн ба Хан Хэнтий чуулгын барилгын ажилд 1077.9 сая төгрөгийг, аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажилд 6314.8 сая төгрөг, сургууль, цэцэрлэгийн халаалтын зуух, цахилгааны засварын 3 ажилд 132.5 сая төгрөгийг зориулалтын дагуу бүрэн олгожээ.

Хэнтий аймагт УТХО-аар өмнөх онд хийгдсэн ажлууд болон 2016 онд хийгдэж байгаа 10 ТАХ-ний санхүүжилтэд 10615.4 сая төгрөг батлагдсан байна.

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүж их дүн	Гэрээний ашиглалтанд оруулах хугацаа	Ашиглалтанд орсон он сар өдөр
Соёлын төвийн барилга, 300 суудал /Хэнтий, Баян-Адлага сум/	2014	2016	1000	50.0	2015.10.01	2015.10.09
Сургуулийн барилга, 928 суудал /Хэнтий, Хэрлэн сум, 1 дүгээр сургууль/	2012	2016	5,089.90	1,374.50	2016.08.25	2016.08.23
Сургуулийн барилга, 320 суудал /Хэнтий, Батширээт сум/	2013	2016	1,687.50	861.3	2016.12.31	2016.12.07
Сургуулийн барилгын өргөтгөл, спорт заалын барилга /Хэнтий, Хэрлэн сум, "Ханхэнтий" цогцолбор/	2013	2016	2,401.80	600.5	2015.10.15	2015.11.26
Уламжлалт анагаах ухааны төвийн их засвар /Хэнтий, Өндөрхаан/	2015	2016	406	198.6	2016.7.20	2016.09.14
Ханхэнтий чуулгын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2011	2017	8,353.70	1,079.20	2016.05.01	ажил дуусаагүй
Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2012	2016	12,450.90	6,314.80	2016.06.01	ажил дуусаагүй
Сургуулийн халаалтын тогооны засвар /Хэнтий, Баянхутаг сум/	2016	2016	27.0	27.0	2016.06.30	2016.06.22
Сургуулийн уурын зуухны барилга /Хэнтий, Өлзийт сум/	2016	2016	79.5	79.5	2016.08.25	2016.08.24
Цэцэрлэгийн барилгын засвар /Хэнтий, Хэрлэн сум, 4 дүгээр цэцэрлэг/	2016	2016	30.0	30.0	2016.07.05	2016.06.23
УТХО-ын дүн			31,526.30	10,615.40	0	0

Эдгээр ТАХ-ний 20 хувь буюу 3401.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Баян-Адрага сумын Соёлын төв, Хэрлэн сумын Хан Хэнтий цогцолбор сургуулийн барилгын өргөтгөл, спорт заалны барилгын ажлыг 2015 онд дуусган улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

A.5. Гэрээгээр 2016 онд хэрэгжиж дуусах УТХО-ын нийт 8 төсөл арга хэмжээний 2 ТАХ дуусаагүй хугацаа хэтэрч 2017 онд гэрээг сунгасан бол 6 ТАХ –г ашиглалтад хүлээлгэн өгсний 1 ТАХ нь гэрээний хугацааг хэтрүүлсэн байна.Үүнд:

- Уламжлалт анагаах ухааны барилгын засварын ажлыг 24 хоног хугацаа хэтрүүлсний алданги тооцохоор гэрээг дүгнэсэн байна.

A.6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжин хэрэгжсэн ТАХ-нүүд дараах байдалтай байна. Үүнд:

1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга 2013-2017 онд “Хар Чонот” ХХК барьж гүйцэтгэн, 2017 оны 4 дүгээр сарын 04 –нд улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтанд оруулаад байна. Зургийг үзүүлвэл:



Зүүн талаас Б блок



коридорын байдал



урд талаас Б,В блок



зүүн уурд талаас Г блок



Хойд талаас А блок



өрөө тасаг

2. Хан Хэнтий чуулгын барилгын ажлын гүйцэтгэл 67 хувьтай байгаа бөгөөд аймгийн Засаг дарга “Макс майнд” ХХК – тай гэрээг 2017 оны 10 сарын 01 хүртэл сунган байгуулсан боловч 2017 оны 3 сард газар дээр нь очиж үзэхэд зогсонги байдалтай, ажил эхлээгүй байв.



А.9. Хөгжлийн банкны эх үүсвэрээс 3 ТАХ-г санхүүжүүлэхээр 4360.5 сая төгрөг батлагдсан бөгөөд дараах ажлууд хэрэгжсэн байна.

Эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тайлбар
Хөгжлийн банкны эх үүсвэрээс	Хэрлэн голын төмөр бетон гүүр /Хэнтий, Баянмөнх сум/	2011	2016	3,800.00	736.3	2016.12.14 нд улсын комисс хүлээн авсан
Хөгжлийн банкны эх үүсвэрээс	Багануур-Цэнхэрмандалын 35 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Хэнтий /	2015	2016	3,415.80	2549.7	
Хөгжлийн банкны эх үүсвэрээс	Инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/	2014	2017	4,374.30	1,074.50	2015.11.02 нд улсын комисс хүлээн авсан

1. “Сумын төсвийн шинэчлэл төсөл” 2014 оноос 2017 онд хэрэгжихээр Төсвийн тухай хуульд багц дүнгээр тусгагдсан ба Биндэр суманд эхлүүлсэн уг ТАХ-ний хүрээнд 2016 онд хийгдсэн ажил байхгүй, ажил удаашралтай, гүйцэтгэл дутуу байна.



төвлөрсөн уурын зуухны барилга

Шугам сүлжээ тавих ажил

УТХО-аар хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт шаардлага хангах хэмжээнд хүрэхгүй байна.

А.10. УТХО-ын төсөл арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжүүлсэн 5, ТЭЗ-д эрх шилжүүлсэн 4 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг дангаараа, 1 ТАХ-нд Барилгын хөгжлийн төвийн барилга захиалагчийн хэлтэстэй хамтран хэрэгжүүлж, гүйцэтгэлийг баталгаажуулжээ.

Гэвч хяналт хэрэгжүүлсэн барилга болон их засварын ажлын чанар, үр дүнд хангалтгүй байдал гарсаар байгаа нь хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Тухайлбал: Уламжлалт анагаах ухааны төвийн барилгын дээврийн засварын ажил үр дүнгүй болжээ.

А.11. Барилгын ажил дээр зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

УТХО-ын зарим ТАХ-ний үр дүн хангалтгүй, чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байна.

А.12. Хөрөнгө оруулалтын баригдсан барилга, хийгдсэн засварын ажилтай танилцахад ажлыг чанаргүй гүйцэтгэсний улмаас эвдрэл, гэмтэл гарсан байна. Тухайлбал:

1. Батширээт сумын 320 хүүхдийн сургуулийн барилгыг “Эрхэт наран” ХХК барьж гүйцэтгэн, 2016 оны 12 дугаар сарын 07-нд улсын комисс хүлээн авч, ашиглалтанд орсон боловч улсын комиссын өгсөн үүрэг даалгаврын дагуу хийх ажлын 20-30 хувийг хагас дутуу хийж, зарим ажлыг огт гүйцэтгээгүй байна.

Мөн барилгын бохирын системд доголдол гарсны улмаас нойлын өрөөний үйл ажиллагаа бүрэн зогссон, 2 ангид дээврээс ус гоожин дусаал үүссэн, үүний улмаас коридорт малын шивтэр мэт эвгүй үнэр тархсан, сантехникийн шугамын төмөр турбанууд 2 ангид гагнагдсан бэхлэгзээнээсээ салж, цүлхийж гарч ирсэн зэрэг бусад эвдрэл, гэмтэл гарсан байна.



Дээврээс ус гоожсон, хана, цонхны хэсгийн замаск хуурч ховхорсон байдал

2. Уламжлалт анагаах ухааны төвийн гадна фасад, бохирын шугам, дээврийн их засварын ажлыг “Баян Бридж” ХХК 72.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн боловч дээврээс цасны ус нэвтэрч дээд давхрын ихэнх өрөөнүүдийн тааз ханын хэсэг, булангуудад мөөгөнцөр үүсч, халтартсан, дусаал гоожсон байна.



Дээрхи байдлаас үзэхэд гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд барилга угсралт, их засварын ажлуудыг чанаргүй хийж гүйцэтгэн ашиглалтанд хүлээлгэн өгч байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

Мөн барилга байгууламжийн гүйцэтгэлийн хувьд олон жил он дамжин баригдаж байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна.

Тухайлбал: Хэнтий аймгийн Биндэр суманд баригдаж буй 640 хүүхдийн сургуулийн барилга 2009 онд, Хан Хэнтий чуулгын барилга 2011 онд тус тус эхэлсэн боловч одоог хүртэл баригдаж дуусаагүй байна.

А.13. Гүйцэтгэсэн бүх төсөл арга хэмжээг улсын комиссын актаар хүлээн авсан боловч комиссын актын хувийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй тохиолдол гарсан байна. Тухайлбал:

- Баянхутаг сумын сургуулийн уурын зуухны засварын ажил, Баянмөнх сумын гүүрний барилгын хүлээлцсэн актыг ашиглагч байгууллагад хүргүүлээгүй байна.
- Баянхутаг сумын сургуулийн уурын зуухны засварын ажлыг хүлээн авахад ашиглагч байгууллагын төлөөлөл оролцоогүй байна.

2013 онд ТАХ-г улсын комисс хүлээж аваагүй, улсын комиссын акт гараагүй байхад ашиглалтанд оруулсан байна.

А.14. Аудитын явцад өмнөх онуудад УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний талаар дараах байдал илэрсэн:

Баян-Адрага суманд 2010-2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Өү-Ти-Юу” ХХК барьж гүйцэтгэсэн “Монгол хатдын өргөө” цогцолбор барилга, “Монгол ээж” музейн барилгыг улсын комисс хүлээн аваагүй, улсын комиссын акт гараагүй байхад аймгийн ИТХ-ын 2013 оны 06 сарын 13-ны 67 дугаар тогтоолоор “Монгол хатдын өргөө цогцолборын ашиглалтын өмнөх захиргаа” нэрээр хуулийн этгээдийн бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна. Уг барилгыг одоо болтол улсын комисс хүлээн аваагүй байна.

/сая төгрөгөөр/

Төсөл арга хэмжээ	Анхны батлагдсан төсөвт өртөг	Олгосон санхүүжилт	Дутуу санхүүжилт	Санхүүжилтийн хувь
"Монгол хатдын өргөө" цогцолбор барилга	2249.1	2027.6	221.5	99.8
"Монгол ээж" музейн барилга	4450.0	4440.0	10.0	90.1

Уг барилга, музей нь Баян-Адрага сумын ЗДТГ-ын данс бүртгэлд дуусаагүй барилгаар бүртгэлтэй байна.

УТХО-аар баригдсан барилга байгууламж, нийлүүлсэн тоног төхөөрөмжийг данс бүртгэлд бүртгэсэн эсэхэд салбарын яамнаас тавих хяналт хангалтгүй байна.

А.15. УТХО-аар 2016 онд хэрэгжүүлж дууссан барилга байгууламж болон БСШУЯ, ЭМСШУЯ, ХНХЯ сайдын багцаас нийлүүлсэн тоног төхөөрөмжийг холбогдох байгууллагын данс бүртгэлд орлогоор бүртгэсэн эсэхийг тулгахад зарим барилга байгууламж, тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаагүй байна. Тухайлбал:

- ГХБХБГазрын конторын барилга, Баянмөнх сумын гүүр, Баянхутаг сумын сургуулийн уурын зуухны засварыг данс бүртгэлд аваагүй байна.
- 2016 онд БСШУСайдын багцаас хуваарилсан 253.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тулгахад Хэрлэн сумын 1-р сургуульд 7.8 сая төгрөгийн төхөөрөмж яамнаас ирээгүй, Яслид ирүүлсэн 1.2 сая төгрөгийн ширээний компьютерийн иж бүрдлийг орлогоод авалгүй орхигдуулсан, Баянмөнх сумын Сургуульд олгосон 10.8 сая төгрөгийн 10 ширхэг сурагчийн зөөврийн компьютерийг орлогоор бүртгээгүй зэрэг 19.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.
- Шинэ зууны төслийн хүрээнд 25 сургуульд хуваарилан ирүүлсэн проектор, электрон самбарыг бүртгэсэн эсэхийг тулгахад Баянмөнх, Дадал, Дэлгэрхаан, Норовлин, Гурванбаян сумын сургуулиуд 33.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг орлогоор бүртгээгүй байна. Эдгээр хөрөнгүүдийг 2017 онд тухайн байгууллагад хүргүүлсэн байна.
- ЭМ сайдын багцаас хуваарилсан тоног төхөөрөмжийг тулгахад аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 15.0 сая төгрөгийн үнэтэй төрөх ор 2 ширхэг хуваарилсаныг тулган үзэхэд 1 ш ор ирсэн ба баримт падаан ирээгүй учир данс бүртгэлд тусгаагүй байна.

Салбарын яамдаас хуваарилсан хөрөнгүүдийг байгууллагуудад тухайн онд нь багтааж цаг хугацаанд нь хүргүүлдэггүй, баримт падаан ирүүлдэггүй, нийлүүлсэн хөрөнгийг тайлан балансад орлогоор бүртгэсэн эсэхийг яам болон аймгийн БСУГ, ЭМГ тулган тооцож хянадаггүй зэрэг ажлын уялдаа холбоогүй байдлаас шалтгаалан хөрөнгүүд эзэнгүйдэх, үрэгдэх нөхцөл бүрдэж байна.

Б. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гэрээ 100 хувь бодитой хэрэгжиж, ихэнхи ТАХ-ний үр дүн сайн байна.

Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцлүүд тодорхойгүй, ерөнхий байдалтай байна.

Б.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр батлагдсан ТАХ-нүүд 100 хувь хэрэгжиж дууссан байна.

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гүйцэтгэгч	Гүйцэтгэлийг хүлээн авсан огноо
1	Баян-Адарга автомашин	40.0	40.0	Мөнхийн дуурлиг ХХК	2016.09.01
2	Баян-Овоо автомашин	40.0	40.0	Саннистронг ХХК	2016.11.08
3	Ёслол хүндэтгэлийн өргөөний тавилга эд хогшил	49.5	49	Алсын солонго ХХК	2016.06.24
4	Ёслол хүндэтгэлийн өргөөний тоног төхөөрөмж	49.0	45.7	Квант сервис ххк	2016.06.09
5	Ёслол хүндэтгэлийн өргөөний ханын зураг	7.5	7.5	Д.Батхуяг	2016.06.15
6	Төрийн үйчилгээний нэгдсэн төвийн тавилга, эд хогшил	34.5	34.5	Алсын солонго ХХК	2016.03.29
7	Төрийн үйчилгээний нэгдсэн төвийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл	26.4	26.4	Квант сервис, Хаан хатдын зоог ХХК	Хаан хатдын зоог ХХК 2016.03.28
8	ТҮНТөвийн дугаарлалтын машин, үнэлгээний систем камер, программ хангамж	12.0	10.9	ЭХОМН ХХК	2016.05.05
9	Хэрлэн сумын багууд компьютер	7.2	7.2	Майтеч ХХК	2016.06.15
10	Татварын хэлтэс компьютер, принтер	32.3	32.0	Майтеч ХХК	2016.06.13
11	Батширээт сумын ЕБСургууль камер	3.5	3.5	Б.Оюунбилэг	2016.12.04
12	ХХААГ-азрын хог хаягдал шатаах зуух барих	5.0	5.0	Жинс ХХК	201..07.05
13	Аймгийн МСҮТөвд сандал	13.5	12.9	Алсын солонго ХХК	2016.07.08
14	Хэрлэн сумын 3-р баг С-79-р байрны мансардны засвар	80.0	80.0	Жоншт	2016.11.22
15	Бор-Өндөр сумын МСҮТөв авто засварын төв худалдан авах	55.3	53	Д.Болдхүү	2016.12.15
16	Дадал сумын Хилийн цэргийн 0287-р ангийн штаб,буудлын барилгын өргөтгөл барих	52.8	52.8	Мянган -Эргэлт ХХК	2016.09.12
17	Иргэдэд үйлчлэх танхимийн засварын ажил /Цагдаагийн газар/	4.0	4.0	Цагдаагийн газар	2016.07.19
18	Хэрлэн сумын 2-р багийн 800 метр авто зам	388	388.0	Хөвчийн зам ХХК	2016.08.13
19	Гурванбаян тосгоны Дундбаяны модон гүүрийг шинээр барих	40.0	40.0	Үвгэн баавай ХХК	Комисс аваагүй
20	Ёмнөдэлгэр сумын Жаргалантын гүүр барих	15.0	15.0	"Зүрх" бүлэг	2016.10.10
ОНХО-ын дүн		955.5	947.4	-	-

Санхүүжилтийг зориулалтын дагуу бүрэн олгосон байна.

Б.2. Аймгийн төрийн сангаас 947.3 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-д холбогдох баримт материалыг үндэслэн санхүүжүүлсэн байна.

Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлсэн “Шинэ Өндөрхаан хорооллын гадна цахилгаан хангамжийн угсралтын ажил”-д 350.6 сая төгрөгийг АЗДТГ-ын нэмэлт дансаар дамжуулан зарцуулсан байна.

Гэрээний хугацаа хэтрэлтэд алданги тооцох боломжгүй болжээ.

Б.3. ТАХ-ний тендерийн бичиг баримтад гэрээний тусгай нөхцлүүдийг тусгасан ч зарим худалдан авах гэрээнд тусгалгүй худалдан авалтыг хийсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн 6 ТАХ-ний ажил гүйцэтгэх гэрээний хугацаа нийт 386 хоногоор хэтэрсэн боловч алданги тооцох боломжгүй болжээ. Үүнд:

- С-79 байрны мансардны засварын ажлыг гүйцэтгэхдээ 144 хоног хэтрүүлсний 5.7 сая төгрөг алдангийг тооцоогүй ба засварын ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй нэмэлт ажлыг гүйцэтгүүлсэн нь хугацаа хэтрэлтэд нөлөөлсөн байна.
- Бусад 5 ТАХ-г гүйцэтгэх гэрээг алданги тооцох заалтгүй, ерөнхий байдлаар байгуулсан, санхүүжилтийг гэрээний хугацаанд олгоогүй зэрэг нөлөөлжээ.

Сумын ТЕЗ-д эрх шилжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт дутмаг байна.

Б.4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-үүд бүрэн хэрэгжсэн боловч захиалагчийн хяналт хангалттай биш байдал ажиглагдлаа.

Сумын ЗД-т эрх шилжсэн Дадал сумын 0287 дугаар ангийн штаб, буудлын өргөтгөлийн барилга, Өмнөдэлгэр сумын Жаргалантын гүүр, Гурванбаян сумын Дундбаяны голд баригдсан гүүрүүд нь хяналтын зураг төсөвгүй боловч гүйцэтгэгч компанийн баталгаажаагүй зургаар баригдсан, эдгээр ажлын явцад сумын ажлын хэсэг хяналт тавьсан нь ТАХ-ний чанар, стандартад мэргэжлийн зүгээс тавих хяналт дутмаг байгаатай холбоотой байна.

Энэ нь ТЕЗ нар Барилгын тухай хуулийн 37.1⁵ дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах ажлын уялдаагүй байдалтай холбоотой байна.

Хэрэгжсэн ТАХ-г улсын комисс хүлээж аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Б.5. Гурванбаян тосгоны Дундбаяны 10 тн-ын даацтай гүүрийн ажлыг “Үвгэн баавай” ХХК хэрэгжүүлж дууссан боловч улсын комисс хүлээн аваагүй байна. Улсын комиссын хүлээн авсан акт гараагүй байхад Гурванбаян сумын ТЕЗ санхүүжилтийг бүрэн олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”-ын 3.5.7⁶ дахь заалтыг зөрчсөн байна.

⁵ Барилгын ажлын захиалагч дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.6.энэ хуулийн 48.1-д заасны дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах; 37.1.19.барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах;

⁶ 3.5 ... дараах материалыг үндэслэн хянаж санхүүжүүлнэ. 3.5.7 Барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтанд хүлээн авсан тухай улсын комиссын акт, техникийн комиссын акт, тоног төхөөрөмж хүлээн авсан акт

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тодорхой ажлуудын үр дүн, үр ашиг сайн байна.

Б.6. Нийт 21 ТАХ-нээс 13-г газар дээр нь очиж танилцахад бодитоор хэрэгжүүлсэн ба дийлэнх нь хэрэгцээ шаардлага хангасан үр дүнтэй ажил болжээ. Тухайлбал:

1. Шинэ Өндөрхаан хорооллын гадна цахилгааны ажлыг иргэд болон аймгийн Засаг дарга, иргэд Ерөнхий сайдад хүсэлт тавьсаны дүнд хамтран ажиллах гэрээ байгуулан, Засгийн газрын нөөц сангаас 350.6 сая төгрөгийг санхүүжилтийг шийдвэрлүүлэн, хэрэгжүүлсэн нь Шинэ Өндөрхаан хороололд баригдсан барилга байгууламжуудыг ашиглалтанд оруулахад чухал үр дүнтэй ажил болжээ.



2. Чингис цамхагт Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөнд тавилга эд хогшил 49.5 сая төгрөг, тоног төхөөрөмж 49.0 сая төгрөг, ханын зураг 7.5 сая төгрөгөөр худалдан авч шинээр тохижуулж ашиглалтанд оруулсан байна.



3. Засгийн газраас өгсөн үүрэг даалгаврын дагуу Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг “Эвт” худалдааны төвд байгуулж тавилга эд хогшил 34.5 сая төгрөг, тоног төхөөрөмж дагалдах хэрэгсэлд 26.4 сая төгрөг, программ хангамж, камержуулалтад 12.0 сая төгрөгөөр гүйцэтгэн ашиглалтанд оруулж, иргэдэд үйлчилж байна.



4. Хэрлэн сумын 2-р багийн нутагт Хөвчийн зам ХХК 800 м хатуу хучилттай авто зам тавих ажлыг барих-шилжүүлэх концессын гэрээгээр гүйцэтгэн, ашиглалтанд оруулсан байна.

5. Баян-Адрага сумын ЗДТГ-т автомашин авах ТАХ-г сумын Засаг даргад эрх шилжүүлсний дагуу сумын ЗД худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Баян-Адрага сумын худалдан авалт өмнөх онуудын худалдан авалттай

харьцуулахад ашиглалтын шаардлага хангах байдал сайжирч, ТАХ-ний тоо хэмжээг нэмэгдүүлсэн байна.

д/д	Сумд	Автомашины марк	Хөдөлгүүр ийн багтаамж	Үйлдвэрлэ сэн он	Монголд орж ирсэн он	Үнэ сая.төг
1	Баян-Адрага	Land cruiser 100	B 4660	2005	2010.05.26	31.5
2	Баян-Адрага	HYUNDAI	D 2400	2001	2016.08.10	8.5

Б.7. ОНТХО-аар санхүүжүүлсэн ихэнх төсөл арга хэмжээний ашиглалт хэвийн байгаа боловч зарим ажлын хувьд хөрөнгө оруулалтын үр дүн хангалттай биш, худалдан авсан объект, зүйлсийн чанар байдал сайн биш байдал харагдлаа.

- С-79 байрны мансардны засварын ажлыг 80.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн нь уг мансардын барилгын ажлын дотоод засал дутуу ажлыг гүйцээж, захиалагч иргэдийг байранд оруулах зорилго хангагдсан боловч уг мансардыг өмнө барьсан “Эрдэм түм” ХХК нь стандарт, технологийн дагуу бариагүйгээс одоогийн байдлаар цасны уснаас зарим орцны дээвэр дээрээсээ нурсан, айлуудын дээвэр, хана мөөгөнцөртөж, халтарсан, хүйтэн байдалтай байна.
- Гурванбаян тосгоны Дундбаяны гүүрийг “Үвгэн баавай” ХХК 40.0 сая төгрөгөөр барьж дууссан боловч хүнд даацын автомашин явахад цөмөрч, ашиглах боломжгүй байдалтай байна.



Дээрхи гүүрний ажлын гүйцэтгэлийн чанар нь зураг төсөвгүй батлагдсан, тусгай зөвшөөрөлгүй ААН-ээр гүйцэтгүүлэн, материалын чанар, стандарт болон технологийн дагуу баригдсан эсэхэд тавих мэргэжлийн хяналт тавигдаагүй, улсын комисс ажиллаагүй зэрэг нөлөөлжээ.

- Бор-Өндөр сумын МСҮТ-д 52.3 сая төгрөгөөр авто засварын төвийн барилгын зориулалтаар худалдан авсан барилгын чанар байдал сайн биш байна.



Дээрх төсөл арга хэмжээнүүдийн чанар байдал нь ОНХО-ын үр дүнг бууруулж байна.

Б.8. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн их засвар, тоног ТАХ-г байгууллагын үндсэн хөрөнгөд бүрэн бүртгэж, тайланд тусгасан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлсэн байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн боловч зарим тохиолдолд ажлын чанар, стандартад нийцэж байгаа эсэхэд тавих хяналт хангалтгүй, эрх шилжсэн ажлын гэрээг дүгнээгүй байна.
2. УТХО-аар хэрэгжиж улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан зарим сургуулийн барилгын сантехник, дулааны шугамын чанар ашиглалтын шаардлага хангахгүй байна.
3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-г улсын комисс хүлээж аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгож, ашиглалтанд оруулсан байна.
4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ихэнх төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна.
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламж, нийлүүлсэн тоног төхөөрөмжийн бичиг баримтыг ашиглагч байгууллагад хүргүүлж, данс бүртгэлд тусгуулах арга хэмжээ хангалтгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн ГХБХБГ-ын дарга-д

1. Улсын комиссын актаар хүлээн авсан барилга байгууламжийн ашиглалтад илэрсэн зөрчил дутагдал, ашиглалтын болон чанарын шаардлага хангахгүй асуудлыг барилга байгууламжийн баталгаат хугацаанд арилгуулах арга хэмжээг зохион байгуулах
2. УТХО болон ОНТО-аар хэрэгжиж буй барилга байгууламжийн явц, хэрэгжилтэнд тавих захиалагчийн болон мэргэжлийн хяналтын үр дүнг сайжруулж ажиллах

СТСХ-ийн дарга-д

3. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо Сангийн сайдын 2016 оны 455 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлангалтын журам”-ын 4.5.10 дахь заалтыг мөрдөж ТАХ-г хүлээн авсны дараа эцсийн санхүүжилтийг олгох

БҮЛЭГ 4: ВЕКСЕЛИЙН ХӨРӨНГӨӨР 2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

2016 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон хуулиар векселиэр санхүүжүүлэх ТАХ-нд Хан Хэнтий чуулгын барилгын 1042.8 сая төгрөгийг УТХО-тай давхардуулан баталсан байна.

4.1. 2016 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон хуулиар Хэнтий аймагт векселиэр санхүүжих ТАХ-г хүснэгтээр үзүүлвэл:

Хуулийн дугаар	ТЕЗ	Эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гэрээний ашиглалтанд оруулах хугацаа	Ашиглалтанд орсон он сар өдөр
Век-II.1.1.5	ШС	Вексель	Аврах гал унтраах ангийн барилга /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	2013	2016	1,250.00	130	2015.12.20	2016.2.08
Век-VIII.1.10	БХБС	Вексель	Аймаг, нийслэлийн бүсийн тулгуур төвүүдэд барилгын материалын жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж барилгын материалын иж бүрэн лаборатори байгуулах /Хэнтий/	2012	2016	719.3	266.2	2016.09.30	2016.12.23
Век-Х1.1.1.11	БСШУСС	Вексель	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Хэнтий, Мөрөн сум/	2013	2016	654	132.8	2015.08.20	2015.10.23
Век-Х1.1.1.42	БСШУСС	Вексель	Сургуулийн дотуур байрын барилга, 80 ор /Хэнтий, Өмнөдэлгэр сум, Балданбэрээвэн хийдийн уламжлалт соёлын сургууль/	2014	2016	1,000.00	302.7	2015.10.25	2015.11.27
Век-Х1.1.1.43	БСШУСС	Вексель	Дотуур байрын барилга, 80 ор /Хэнтий, Баянмөнх сум/	2013	2016	1,042.00	193.5	2015.08.20	2015.09.08
Век-Х1.1.1.68	БСШУСС	Вексель	Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Биндэр сум/	2009	2016	1,830.00	203.6		ашиглалтанд ороогүй
Век-Х1.1.1.94	БСШУСС	Вексель	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Хэнтий, Хэрлэн сум/	2013	2016	850	101.4	2014.12.25	2015.08.28
Век-Х2.1.7	БСШУСС	Вексель	Ханхэнтий чуулгын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2011	2016	8,353.70	1,042.80	2016.05.01	ашиглалтанд ороогүй
Векселийн дүн						15,699.00	2,373.00		

4.1. 2016 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон хуулиар Хэнтий аймагт векселиэр санхүүжих ТАХ-ний жагсаалтад 2011-2016 онд шилжин хэрэгжсэн болон өмнөх онд хэрэгжиж дууссан ТАХ-нүүд батлагджээ. Эдгээр ТАХ-ний 4-ийг нь 2015 онд улсын комисс хүлээн авч ашиглалтанд орсон, 1 ТАХ-г 2016 онд улсын комиссын актаар хүлээн авсан бол 2 ТАХ нь дуусаагүй, 1 ТАХ-г хэсэгчилэн хүлээн авч, бүрэн дуусаагүй байна.

4.2. Хөрөнгө оруулалтын ТАХ-нүүдээс аймгийн ТЕЗ-д эрх шилжин хэрэгжсэн ТАХ байхгүй, худалдан авах ажиллагаа, гэрээ байгуулалт, явц, гүйцэтгэлийн хяналт, санхүүжилтийг салбарын яамдаас хэрэгжүүлсэн байна.

4.3. Мөрөн сумын Цэцэрлэгийн барилга, Баянмөнх сумын дотуур байрны барилга, Хэрлэн сумын Цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ-ын хяналтын инженерүүд хэрэгжүүлж, барилгын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулсан байна.

Бэрх тосгоны гал унтраах ангийн конторын барилгад захиалагчийн хяналтыг ОБЕГ-аас хэрэгжүүлсэн байна.

- 4.4. 2016 онд улсын комисст хүлээлгэн өгсөн Бэрх тосгоны аврах гал унтраах ангийн барилгын ажлын конторын хэсгийг 49 хоног, аймгийн ГХБХБГ-ын конторын барилгын ажил 83 хоног гэрээнээс хугацаа хоцроож улсын комисст хүлээлгэн өгсөн байна.
- 4.5. 2011-2016 онд хэрэгжиж буй Биндэр сумын сургуулийн барилгын ажил хэрэгжиж дуусаагүй, 2016 онд 203.6 сая төгрөг батлагдсан боловч ажил явагдаагүй байна.
- 4.6. Хан Хэнтий чуулгын барилга нь 2011-2016 онд хэрэгжиж, 2016 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон хуулиар улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэхээр БСШУС-ын багцад XI.2.1.7-д 1079.2 сая төгрөгөөр санхүүжихээр давхар тусгагдсан бөгөөд 2016 онд аймгийн ТЕЗ-д эрх шилжин хэрэгжиж, 1079.2 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Төсвийн тухай хуульд тусгагдсан ТАХ-ний зориулалтыг өөрчилж хэрэгжүүлсэн байна.

- 4.7. 2012-2015 оны Монгол Улсын төсвийн тухай хууль болон Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулиар батлагдсан “Аймаг нийслэлийн бүсийн тулгуур төвүүдэд барилгын материалын жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж барилгын материалын иж бүрэн лаборатори байгуулах” 719.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ТАХ-г хэрэгжүүлэхдээ төсөл арга хэмжээний зориулалт өөрчлөгдөн аймгийн ГХБХБГ-ын конторын барилгын ажил гүйцэтгэн 2016 оны 12.23-нд улсын комиссоор хүлээн авсан байна.



Уг барилгын подвалд 3 өрөөг лабораторийн зориулалтаар ашиглахаар төлөвлөж хаягжуулсан боловч барилгын материалын иж

бүрэн лаборатори ашиглалтанд ороогүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”-ын 3.25 “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Санхүүжилтийг цаг хугацаанд нь олгоогүйгээс ТАХ-ний хэрэгжилтийн хугацаанд нөлөөлж байна.

4.8. Бэрх тосгонд баригдсан гал унтраах ангийн барилгын ажлын конторын



барилга, автотавиулангийн хэсгийг хэсэгчлэн 2016 оны 2 сарын 08 –нд улсын комисст хүлээлгэн өгсөн байна. Санхүүжилтээс шалтгаалан орон сууцны хэсгийн ажил дутуу, гадна тохижолтын ажил хийгдээгүй байна.



Хүлээлгэн өгсөн зарим барилгын ашиглалтын явцад сантехникийн болон дээврээс ус гоожих доголдол гарч байна.

- 4.9. Аудитын хугацаанд ашиглалтанд орсон барилгын ажилтай танилцах явцад дараах доголдолууд гарсан байна. Мөрөн сумын 50 хүүхдийн Цэцэрлэгийн барилгыг Улаанбаатар хотын “Тэгш хүрээ” ХХК барьж дуусган, 2015 оны 11.08- нд ашиглалтанд оруулсан боловч барилгын дээврээс болон цонхны засвараар ус гоожиж хана, таазны эмульс холцорсон ба паарнаас ус гоожсон байдалтай байна.



таазнаас ус гоожсон,

цонхны булан,

паарнаас ус гоожсон байдал

2. Баянмөнх сумын дотуур байрны барилгын ашиглалтын явцад сантехникийн доголдол гарч 2 давхарын паарнаас ус алдснаас болоод 1 давхарт ус нэвтэрч гоожсон байна.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. 2016 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон хуулиар векселиэр санхүүжүүлэх ТАХ –г УТХО-тай давхардуулан баталсан байна.
2. Төсвийн тухай хуульд тусгагдсан ТАХ-ний зориулалтыг өөрчилж хэрэгжүүлсэн байна.
3. Санхүүжилтийг цаг хугацаанд нь олгоогүйгээс ТАХ-ний хэрэгжилтийн хугацаанд нөлөөлж байна.
4. Улсын комиссын актаар хүлээн авч, ашиглалтад оруулсан дотуур байрны болон цэцэрлэгийн барилгын сантехник, дулааны шугам сүлжээнд доголдол гарч байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн ГХБХБГ-ын даргад

1. Улсын комиссын актаар хүлээн авсан барилга байгууламжийн ашиглалтад тухай бүр хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдал, ашиглалтын болон чанарын шаардлага хангахгүй асуудлыг барилга байгууламжийн баталгаат хугацаанд арилгуулах арга хэмжээг зохион байгуулах
2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжийн явц, хэрэгжилтэнд тавих захиалагчийн болон мэргэжлийн хяналтын үр дүнг сайжруулж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 11 дүгээр сарын 25-ны дотор аймгийн Аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг мэдэгдье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:

Дараах санал, зөвлөмжийг салбарын сайдуудад хүргүүлэх нь зүйтэй байна. Үүнд:

Сангийн сайдад:

1. Төсвийн тухай хуулийн 4.1.24, 6.6.6-ын заалт нь мөн хуулийн 58.2.17 дахь заалт болон бусад салбарын хуулийн заалттай нийцэхгүй зөрчилдөж байгааг анхаарч хуульд өөрчлөлт оруулах арга хэмжээ авах
2. Төсвийн тухай хуулиар төсөл арга хэмжээг давхардуулан батлуулахгүй байх

ЭМСайд, БСШУ-ны сайд нарт:

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сангийн сайдын 2016 оны 455-р тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын дагуу баригдаж дууссан барилга байгууламж болон нийлүүлсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг хүлээн авсан байгууллагын данс бүртгэлд бүрэн тусгуулахад тавих хяналтыг сайжруулах

Салбарын сайд нарт:

4. Он дамжин хэрэгжиж байгаа дуусаагүй барилга байгууламжийн ажлыг төсөвт тусгуулж, гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг сайжруулж ажиллах

ТАЙЛАН БИЧСЭН:

Аймгийн Аудитын газрын

Ахлах аудитор

Н.Туяа

2017 оны 04 дүгээр сарын 20

Аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн албан бичиг


**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬГА
ХЭНТНИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**
23119 Хэнтийн аймаг, Хэрлэн сум, Сарниг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2017.04.17 № 75
танил _____ -ы № _____ -т

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Н.ГАНБЯМБА ТАНАА**

"Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг" –т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүргүүлэв.

Гүйцэтгэлийн аудитын тайланг 04 дүгээр сарын 20-нд Үндэсний аудитын газарт хүргүүлэх тул тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох саналаа албан бичгээр энэ хугацаанд багтаан саналаа ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.ЭНХТҮВШИН

1700887

Холбогдох байгууллагын санал


**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**
23119 Чингис хот, Хэнтий аймаг,
Утас/Факс: 70-56-24-12
E-mail: infoazdtg@khentii.gov.mn


2017.04.19 № 3/847


танай 2017.04.17-ны № 75 -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжтэй санал нийлж байна.


САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  С.НЯМДАВАА
CICA0005 9076603

АА-НТү89

тайлангуудтай.

14/19 001072

Тайлангийн баталгаажуулалт



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2017 оны 04 дугаар сарын 20 Дугаар 14 Чингис хот

Г Гүйцэтгэлийн аудитын тайланг батлах тухай Г

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаалаар баталсан "Нийслэл болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх"-ийн 5, Чанарын хяналтын журам-ын 5.3.4, Аймгийн аудитын газрын Удирдах Зөвлөлийн 4 дүгээр сарын 19 -ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Н.Туяад даалгасугай.
3. Аудитын ажлыг үнэлж дүгнэн, үр өгөөжийг тооцож ажиллахыг аудитын менежер Б.Наранцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.ЭНХТҮВШИН

1200134

№	Байгууллагын нэр	Илэрсэн зөрчил		Эцсийн шийдвэр
		Нөхцөл байдал	мөнгөн дүн	
1	Дундбаян ТЭЗ, Өмнөдэлгэр ТЭЗ	Орон нутгийн замын сангаас Гурванбаян тосгоны Дундбаяны модон гүүр барихад 40.0 сая төгрөг, Өмнөдэлгэр сумын Жаргалантын гүүрний засварт 15.0 сая төгрөгийг батлагдсан зураг төсөвгүйгээр төлөвлөжээ.	55.0	Зөвлөмж
2	Сангийн яам	Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан хуулиар УТХО-аар санхүүжүүлэх ТАХ-г төлөвлөж батлахдаа Хан Хэнтий чуулгын барилгыг 1079.2 сая төгрөгөөр улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр баталсан бол 1042.8 сая төгрөгийг векселээр санхүүжүүлэхээр давхардуулан баталсан байна.	1042.8	зөвлөмж
3	Дундбаян ТЭЗ, Өмнөдэлгэр ТЭЗ	Сумын ТЭЗ-д эрх шилжүүлсэн Өмнөдэлгэр сум, Гурванбаян сумын нутагт гүүр барих 2 ТАХ-ний гүйцэтгэчийг шалгаруулахад тусгай зөвшөөрөлгүй ААН, иргэдийн бүлэгтэй шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь "Авто замын тухай" хуулийн 13.2, 13.3 заалтыг зөрчсөн байна.		Зөвлөмж
4	Хэрлэн, Баян-Адрага, Баян-Овоо, Дадал, Өмнөдэлгэр сумын ТЭЗ	Шилэн дансны нэгдсэн цахим сайтад хөрөнгө оруулалтын ТАХ-ны худалдан авах ажиллагааны тайланг мэдээлсэн эсэхийг шалгахад Хэрлэн, Баян-Адрага, Баян-Овоо, Дадал, Өмнөдэлгэр сумын ТЭЗ нар мэдээллийг байршуулаагүй, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг бүрэн хангаагүй, Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	206.6	Зөвлөмж
5	ГХБХБГ	Сайдын эрх шилжүүлсэн тушаалын дагуу 2015 оны 6 сарын 12 нд барилгын ажлын зураг төсөв, баримт бичгийг акт үйлдэн хүлээлцэж, Аймгийн Засаг дарга Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажлыг гүйцэтгүүлэх гэрээг Хар чонот ХХК-тай байгуулсан байна. Гэвч гэрээ байгуулсан он сар өдөргүй, санхүүжилтийн талаар нарийвчлан тусгаагүй, хугацаа хэтрэлтэд алданги тооцох заалтгүй байгуулж, гэрээний биелэлтийг дүгнээгүй, гэрээний хугацаа хэтэрсэн байна.		албан шаардлага
6	Өмнөдэлгэр, Гурванбаян сумын ТЭЗ	Сумын ЗД-т эрх шилжсэн Дадал сумын 0287 дугаар ангийн штаб, буудлын өргөтгөлийн барилга, Өмнөдэлгэр сумын Жаргалантын гүүр, Гурванбаян сумын Дундбаяны голд баригдсан гүүрүүд нь хяналтын зураг төсөвгүй боловч гүйцэтгэгч компанийн баталгаажгаагүй зургаар баригдсан, эдгээр ажлын явцад сумын ажлын хэсэг хяналт тавьсан нь ТАХ-ний чанар, стандартад мэргэжлийн зүгээс тавих хяналт дутмаг байгаатай холбоотой байна.		Зөвлөмж
7	Гурванбаян ТЭЗ	Гурванбаян тосгоны Дундбаяны 10 тн-ын даацтай гүүрийн ажлыг "Үвгэн баавай" ХХК хэрэгжүүлж дууссан боловч улсын комиссын хүлээн аваагүй байна. Улсын комиссын хүлээн авсан акт гараагүй байхад Гурванбаян сумын ТЭЗ санхүүжилтийг бүрэн олгосон байна.	10.0	албан шаардлага
8	ГХБХБГ	Баян-Адрага суманд 2010-2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Өү-Ти-Юу" ХХК барьж гүйцэтгэсэн "Монгол хатдын өргөө" цогцолбор барилга, "Монгол ээж" музейн барилгыг улсын комисс хүлээн аваагүй, улсын комиссын акт гараагүй байхад аймгийн ИТХ-ын 2013 оны 06 сарын 13-ны 67 дугаар тогтоолоор "Монгол хатдын өргөө цогцолборын ашиглалтын өмнөх захиргаа" нэрээр хуулийн этгээдийн бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна. Уг барилгыг одоо болтол улсын комисс хүлээн аваагүй байна. Төсөл арга хэмжээ Анхны батлагдсан төсөвт өртөг Олгосон санхүүжилт Санхүүжилтийн дутуу Санхүүжилтийн хувь-"Монгол хатдын өргөө" цогцолбор барилга 2249.1 2027.6 221.5 99.8 "Монгол ээж" музейн барилга 4450.0 4440.0 10.0 90.1 сая төг		албан шаардлага
9	ГХБХБГ	Уламжлалт анагаах ухааны төвийн гадна фасад, бохирын шугам, дээврийн их засварын ажлыг Баян Бридж ХХК 72.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн боловч дээврээс цасны ус нэвтэрч дээд давхрын бүх өрөөнүүдийн тааз ханын хэсэг, булангуудад мөөгөнцөр үүсч, халтартсан, дусаал гоожсон байна.		албан шаардлага
10	ГХБХБГ	Батширээт сумын 320 хүүхдийн сургуулийн барилгыг "Эрхэт наран" ХХК барьж гүйцэтгэн, 2016 оны 12 дугаар сарын 07-нд улсын комисс хүлээн авч, ашиглалтанд орсон боловч улсын комиссын өгсөн үүрэг даалгаврын дагуу хийх ажлын 20-30 хувийг хагас дутуу хийж, зарим ажлыг огт гүйцэтгээгүй байна. Мөн барилгын бохирын системд доголдол гарсны улмаас нойлын өрөөний үйл ажиллагаа бүрэн зогссон, 2 ангид дээврээс ус гоожин дусаал үүссэн, үүний улмаас коридорт малын шивтэр мэт эвгүй үнэр тархсан, сантехникийн шугамын төмөр турбанууд 2 ангид гагнагдсан бэхэлгээнээсээ салж, цүлхийж гарч ирсэн зэрэг бусад эвдрэл, гэмтэл гарсан байна.		албан шаардлага
11	ГХБХБГ	Мөрөн сумын 50 хүүхдийн Цэцэрлэгийн барилгыг Улаанбаатар хотын Тэгш хүрээ ХХК барьж дуусган, 2015 оны 11.08 нд ашиглалтанд оруулсан боловч барилгын дээврээс болон цонхны дээвэрээр ус гоожиж хана, таазны өмүлс холцорсон ба паарнаас ус гоожсон байна.		албан шаардлага
12	ГХБХБГ	Баянмөнх сумын дотуур байрны барилгын ашиглалтын явцад сантехникийн доголдол гарч 2 давхарын паарнаас ус алдснаас болоод 1 давхарт ус нэвтэрч гоожсон байна.		албан шаардлага

